



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 8778.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт “Бами” ХХК-ийн барьсан Спорт заалны барилга угсралтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал - Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Д.Нямтулга - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын  
техникийн хяналтын улсын байцаагч

Б.Эрдэнэцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын  
эрүүл ахуйн хяналтын Улсын байцаагч

Ш.Мөнхзаяа - Мэргэжлийн хяналтын газрын  
эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Ц.Цогтбаяр -Жаргалант сумын Засаг дарга

Д.Төгөлдөр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Газрын хэлтсийн дарга

Г.Ганжаргал - Онцгой байдлын газрын Гал түймрийн

Улсын хяналтын байцаагч


- |                |   |
|----------------|---|
| Т.Бямбатөмөр   | -“Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компаний ерөнхий инженер            |
| М.Нансалмаа    | -“Шим-ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер |
| А.Пүрэвдорж    | -“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний ерөнхий инженер                         |
| С.Батдорж      | -Аймгийн архивын тасгийн дарга  |
| М.Ганданбаатар | -“Бами” ХХК-ний захирал   |
| Ж.Баярсайхан   | -“Өвлөмж” ХХК-ний захирал   |
| Б.Мөнхбат      | -“BMJ констракшн” ХХК-ний захирал   |

Нарийн бичгийн  
дарга:  
З.Өмиртай

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

2.Тус ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж, хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН